



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠵᠠᠰᠭᠢᠨ ᠭᠠᠷ  
ᠮᠤᠨᠤᠯᠤᠰ

# ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

## 2023 I-VI

## ГАРЧИГ

<b>1. УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАР МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ .....</b>	<b>1</b>
1.1. Эрдэс бүтээгдэхүүний экспортын төсөөлөл, гүйцэтгэл.....	1
1.2. Төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл.....	1
1.3. Уул уурхай, олборлох салбарын төсөвт төвлөрүүлсэн орлого.....	3
<b>2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР.....</b>	<b>4</b>
2.1. Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл.....	4
2.1.1. Уул уурхай, олборлох салбар.....	4
2.1.2. Хүнд үйлдвэрийн салбар.....	4
2.1.3. Газрын тосны салбар .....	4
2.2. Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл.....	6
2.3. Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн.....	7
<b>3. ГАДААД ХУДАЛДАА.....</b>	<b>8</b>
3.1. Эрдэс бүтээгдэхүүний экспорт.....	8
3.1.1. Уул уурхай, олборлох салбар.....	8
3.1.2. Газрын тосны салбар .....	9
3.1.3. Хүнд үйлдвэрийн салбар.....	10
3.2. Эрдэс бүтээгдэхүүний импорт.....	10
3.2.1. Газрын тосны салбар .....	10

## 1. УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАР МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ

### 1.1. ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫН ТӨСӨӨЛӨЛ, ГҮЙЦЭТГЭЛ

УИХ-ын 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр баталсан **МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ** Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтүүдийг хүснэгтээр харуулав.

#### ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ (БИЕТ ХЭМЖЭЭГЭЭР)

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023		Зөрүү	Гүйцэтгэл хувь
			Төл (тод)	I-VII		
1	Нүүрсний экспортын хэмжээг нэмэгдүүлэх	мян.тн	50,000.0	35,419.9	14,580.1	70.8%
2	Зэсийн баяжмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх	мян.тн	1,454.0	891.3	562.7	61.3%
3	Төмрийн хүдэр, баяжмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх	мян.тн	8,420.0	3,140.5	5,279.5	37.3%
4	Алтны олборлолтын хэмжээг нэмэгдүүлэх (МБ-нд тушаасан) <sup>1</sup>	тн	20.7	8.5	12.2	41.2%
5	Газрын тосны экспортын хэмжээг нэмэгдүүлэх	мян.бар	6,500.0	2,776.1	3,723.9	42.7%
6	Цайрын хүдэр, баяжмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх <sup>2</sup>	мян.тн	100.0	107.4	+7.4	+107.4%
7	Хайлуур жоншны хүдэр, баяжмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх <sup>3</sup>	мян.тн	400.0	524.1	+124.1	+131.0%

Эх сурвалж: СЯ, ГЕГ, МБ

### 1.2. ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого 2023 оны эхний 7 сарын байдлаар 12,929.0 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 3,488.6 тэрбум төгрөг буюу 37.0 хувиар өссөн байна. Үүнээс, Эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрүүлсэн орлого 4,327.3 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 2,186.6 тэрбум төгрөг буюу 2.0 дахин өссөн байна. Төсөвт төвлөрүүлсэн орлогын мэдээ, эзлэх хувийг салбараар харуулав.

- Уул уурхай, олборлох 4,102.6 тэрбум төгрөг буюу 31.7 хувь,
- Газрын тос 172.2 тэрбум төгрөг буюу 1.3 хувь,
- ТЗ-ийн төлбөр 19.1 тэрбум төгрөг буюу 0.1 хувь,
- Бусад орлого 33.3 тэрбум төгрөг буюу 0.3 хувь.

<sup>1</sup> Монголбанкны үнэт металл худалдан авалтын мэдээлэл болно.

<sup>2</sup> Цайр нь МУ-ын 2023 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтад тусгагдаагүй заалт болно

<sup>3</sup> Хайлуур жонш нь МУ-ын 2023 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтад тусгагдаагүй заалт болно.

Эрдэс баялгийн салбар нь Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын 33.4 хувийг бүрдүүлж байна.

УЛСЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ОРЛОГО, тэрбум төгрөгөөр

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл / I-VII /		Гүйцэтгэл	
		2022 (Тод)	2023 (Тод)	2022	2023	+/-	Хувь
Нийт орлогын дүн		4,358.3	6,563.1	2,140.7	4,327.3	2,186.6	2.0 <sup>1</sup>
УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ САЛБАР							
Нийт дүн		4,066.3	6,077.3	2,102.2	4,102.6	2,000.4	95.2%
1	Алт	247.4	287.6	133.6	138.4	4.8	3.6%
2	Зэс	1,966.7	2,547.3	1,074.1	1,237.7	163.6	15.2%
3	Нүүрс	1,346.5	2,649.0	719.3	2,489.1	1,769.8	3.5 <sup>1</sup>
4	Төмөр	145.7	270.4	27.0	49.2	22.2	82.0%
5	Цайр	77.9	96.2	93.2	107.5	14.3	15.4%
6	Хайлууур жонш	153.7	65.6	13.4	15.8	2.4	18.0%
7	Бусад	128.4	161.2	41.6	64.8	23.3	55.9%
ГАЗРЫН ТОСНЫ САЛБАР							
8	Газрын тос	215.4	425.0	1.8	172.2	170.5	97.0 <sup>1</sup>
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БОЛОН БУСАД ОРЛОГО							
Нийт дүн		76.6	60.8	36.7	52.5	15.8	42.9%
9	Тусгай зөвшөөрлийн төлбөр	31.4	29.7	18.8	19.1	0.3	1.9%
10	УТ-ийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	17.5	3.0	0.7	0.9	0.2	25.6%
11	Төсөвт байгууллагын өөрийн орлого /СЦ-ын орлого/	25.0	25.0	14.5	29.1	14.6	2.1 <sup>1</sup>
12	Бусад орлого	2.7	3.1	2.7	3.3	0.6	23.4%

Эх сурвалж: СЯ, АМГТТ

Тайлбар: 1 – дахин их

### 1.3. УУЛУРХАЙ, ОЛБОРЛОХ САЛБАРЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ОРЛОГО

2023 оны эхний 7 сарын байдлаар улсын төсөвт 4,102.6 тэрбум төгрөг татвар, хураамж хэлбэрээр төвлөрүүлсэн байна. Өнгөрсөн оны мөн үеэс 2,000.4 тэрбум төгрөг буюу 95.2 хувиар өссөн байна.

Үүнээс:

- Нүүрс 2,489.1 тэрбум төгрөг,
- Зэс 1,237.7 тэрбум төгрөг,
- Алт 138.4 тэрбум төгрөг,
- Цайр 107.5 тэрбум төгрөг,
- Төмөр 49.2 тэрбум төгрөг,
- Хайлуур жонш 15.8 тэрбум төгрөг,
- Бусад ашигт малтмал 64.8 тэрбум төгрөг.

Дараах ашигт малтмалын улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс өссөн үзүүлэлттэй гарсан байна. Үүнд:

- Нүүрс 1,769.8 (3.5 дахин) тэрбум төгрөг,
- Зэс 163.6 (15.2%) тэрбум төгрөг,
- Төмөр 22.2 (82.0%) тэрбум төгрөг,
- Цайр 14.3 (15.4%) тэрбум төгрөг,
- Алт 4.8 (3.6%) тэрбум төгрөг,
- Хайлуур жонш 2.4 (18.0%) тэрбум төгрөг,
- Бусад 23.3 (55.9%) тэрбум төгрөг.

## 2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

### 2.1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

#### 2.1.1. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ САЛБАР

2023 оны эхний 7 сарын байдлаар 39,413.8 мян.тн нүүрс, 825.3 мян.тн зэсийн баяжмал, 3,299.8 тн молибдены баяжмал, 7,825.7 кг алт, 2,564.7 мян.тн төмрийн хүдэр, 1,225.9 мян.тн төмрийн хүдрийн баяжмал, 52.0 мян.тн хайлуур жоншны хүдэр, 79.3 мян.тн хайлуур жоншны баяжмал, 209.8 мян.тн цайрын баяжмал, 8,490.6 тн мөнгөний баяжмал тус тус үйлдвэрлэсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нүүрс 26,770.3 мян.тн буюу 3.1 дахин, зэсийн баяжмал 170.9 мян.тн буюу 26.1 хувь, молибдены баяжмал 211.4 тн буюу 6.8 хувь, хайлуур жоншны баяжмал 71.2 мян.тн буюу 9.8 дахин, мөнгөний баяжмал 5,643.7 тн буюу 3.0 дахин тус тус өссөн байна.

Харин алт 1,767.0 кг буюу 18.4 хувь, төмрийн хүдэр 2,382.3 мян.тн буюу 48.2 хувь, төмрийн хүдрийн баяжмал 51.3 мян.тн буюу 4.0 хувь, хайлуур жоншны хүдэр 3.9 мян.тн буюу 7.1 хувь, цайрын баяжмал 23.6 мян.тн буюу 10.1 хувиар тус тус буурсан байна.

#### 2.1.2. ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

2023 оны эхний 7 сарын байдлаар 3,482.0 мян.тн баяжуулсан нүүрс, 240.8 мян.тн нүүрсэн шахмал түлц, 5,737.6 тн катодын зэс, 23,534.4 тн металл бэлдэц, 22,666.0 тн металл цувимал, 2,199.0 тн ган төмөр хийц тус тус үйлдвэрлэсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад баяжуулсан нүүрс 2,650.8 мян.тн буюу 4.2 дахин, катодын зэс 44.9 тн буюу 0.8 хувь, металл бэлдэц 12,002.5 тн буюу 2.0 дахин, металл цувимал 9,739.3 тн буюу 75.3 хувь, ган төмөр хийц 181.9 тн буюу 9.0 хувиар тус тус өссөн байна.

Харин нүүрсэн шахмал түлц 92.5 мян.тн буюу 27.7 хувиар буурсан байна.

#### 2.1.3. ГАЗРЫН ТОСНЫ САЛБАР

2023 оны эхний 7 сарын байдлаар 2,875.4 мян.бар газрын тос үйлдвэрлэсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2,453.1 мян.бар буюу 6.8 дахин өссөн байна.

## АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

тэрбум төгрөг

№	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжих нэгж	2022		2023		Өөрчлөлт	
			VI	I-VI	VI	I-VI	(6-4)=?, (6/4)=%	
	1	2	3	4	5	6	7	8
<b>1. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТ</b>								
1.1	Нүүрс	мян.тн	2,192.1	12,643.6	5,151.9	39,413.8	26,770.3	3.1 <sup>1</sup>
1.2	Газрын тос	мян.бар	347.4	422.2	422.5	2,875.4	2,453.1	6.8 <sup>1</sup>
1.3	Зэсийн баяжмал, ме/агуулгаар	мян.тн	100.9	654.5	120.6	825.3	170.9	26.1%
1.4	Молибдений баяжмал, ме/агуулгаар	тн	479.0	3,088.4	330.4	3,299.8	211.4	6.8%
1.5	Цэвэршүүлээгүй алт	кг	1,985.2	9,592.7	1,343.9	7,825.7	-1,767.0	-18.4%
1.6	Төмрийн хүдэр, баяжмал:							
	Төмрийн хүдэр	мян.тн	573.6	4,946.9	441.2	2,564.7	-2,382.3	-48.2%
	Төмрийн хүдрийн баяжмал	мян.тн	48.5	1,277.1	227.7	1,225.9	-51.3	-4.0%
1.7	Хайлуур жоншны хүдэр, баяжмал:							
	Хайлуур жоншны хүдэр	мян.тн	7.8	55.9	6.6	52.0	-3.9	-7.1%
	Хайлуур жоншны баяжмал	мян.тн	2.1	8.1	13.7	79.3	71.2	9.8 <sup>1</sup>
1.8	Цайрын баяжмал	мян.тн	32.7	233.4	33.1	209.8	-23.6	-10.1%
1.9	Мөнгөний баяжмал	тн	349.0	2,846.8	1,616.3	8,490.6	5,643.7	3.0 <sup>1</sup>
<b>2. БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР</b>								
<b>2.1. Хүнд үйлдвэр</b>								
2.1.1	Баяжуулсан нүүрс	мян.тн	354.0	831.2	669.5	3,482.0	2,650.8	4.2 <sup>1</sup>
2.1.2	Нүүрсэн шахмал түлш	мян.тн	19.5	333.2	4.6	240.8	-92.5	-27.7%
2.1.3	Катодын зэс, 99%	тн	798.8	5,692.7	863.6	5,737.6	44.9	0.8%
2.1.4	Металл бэлдэц	тн	86.7	11,532.0	3,663.7	23,534.4	12,002.5	2.0 <sup>1</sup>
2.1.5	Металл цувимал	тн	175.7	12,926.7	4,077.0	22,666.0	9,739.3	75.3%
2.1.6	Ган төмөр хийц	тн	0.4	2,017.1	12.3	2,199.0	181.9	9.0%

Эх сурвалж: YCX

## 2.2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ

тэрбум төгрөг

Салбар	2022		2023		Өөрчлөлт	
	VII	I-VII	VII	I-VII	(5-3)=?	(5/3)=%
1	2	3	4	5	6	7
<b>НИЙТ ДҮН</b>	<b>1,624.6</b>	<b>10,169.3</b>	<b>2,391.7</b>	<b>15,575.4</b>	<b>5,406.1</b>	<b>53.2%</b>
<b>УУЛУУРХАЙ, ОЛБОРЛОЛТ</b>	<b>1,153.7</b>	<b>6,650.5</b>	<b>1,753.9</b>	<b>10,963.0</b>	<b>4,312.4</b>	<b>64.8%</b>
Нүүрс олборлолт	272.2	1,212.0	682.4	4,154.7	2,942.7	3.4 <sup>1</sup>
Газрын түүхий тос	121.2	144.5	107.0	741.9	597.3	5.1 <sup>1</sup>
Металлын хүдэр олборлолт	735.7	5,167.9	915.7	5,866.8	699.0	13.5%
Бусад ашигт малтмал олборлолт	19.6	100.7	21.6	123.3	22.6	22.4%
Уул уурхайн туслах үйл ажиллагаа	4.9	25.4	27.2	76.3	50.8	3.0 <sup>1</sup>
<b>БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР</b>	<b>376.9</b>	<b>2,583.1</b>	<b>513.3</b>	<b>3,408.8</b>	<b>825.7</b>	<b>32.0%</b>
<b>Үүнээс, Хүнд үйлдвэр</b>	<b>86.0</b>	<b>555.2</b>	<b>109.6</b>	<b>741.4</b>	<b>186.2</b>	<b>33.5%</b>
Кокс болон газрын түүхий тосны боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	3.0	50.4	1.6	37.1	-13.3	-26.4%
Химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	0.4	5.1	0.5	3.3	-1.8	-35.5%
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1.0	4.3	0.5	5.1	0.8	18.0%
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	49.7	231.2	66.5	321.7	90.5	39.2%
Металл боловсруулах үйлдвэрлэл	6.3	179.8	37.2	240.6	60.8	33.8%
Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1.8	6.3	1.9	16.5	10.1	2.6 <sup>1</sup>
Тээврийн хэрэгслийн бусад тоног төхөөрөмж үйлдвэрлэл	0.8	2.8	0.4	4.1	1.3	45.5%
Бусад боловсруулах үйлдвэрлэл	23.0	75.3	0.9	113.1	37.8	50.2%

Эх сурвалж: ҮСХ

Тайлбар: 1 – дахин их

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2023 оны эхний 7 сарын байдлаар 15.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5.4 (53.2%) их наяд төгрөгөөр өссөн байна. Үүнд, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл 11.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4.3 (64.8%) их наяд төгрөгөөр өсөхөд нүүрс олборлолт 2.9 (3.4 дахин) их наяд төгрөг, газрын түүхий тосны олборлолт 597.3 (5.1 дахин) тэрбум төгрөг, металлын хүдэр олборлолт 699.0 (13.5%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд Уул уурхай, олборлох салбар 70.4 хувийг эзэлж байна.



## 2.3. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН

тэрбум төгрөг

Салбар	2022		2023			Өөрчлөлт	
	VII	I-VII	VII	I-VII	Гад-д	(5-3)=?, (5/3)=%	
1	2	3	4	5	6	7	8
<b>НИЙТ ДҮН</b>	<b>2,703.2</b>	<b>14,299.2</b>	<b>3,552.1</b>	<b>25,098.6</b>	<b>17,742.8</b>	<b>10,799.4</b>	<b>75.5%</b>
<b>УУЛУРХАЙ, ОЛБОРЛОЛТ</b>	<b>2,074.5</b>	<b>10,076.2</b>	<b>2,765.0</b>	<b>19,398.9</b>	<b>17,074.4</b>	<b>9,322.7</b>	<b>92.5%</b>
Нүүрс олборлолт	880.2	2,829.3	1,446.4	10,782.9	9,991.6	7,953.6	3.8 <sup>1</sup>
Газрын түүхий тосны олборлолт	125.4	163.9	102.0	719.4	719.4	555.5	4.4 <sup>1</sup>
Металлын хүдэр олборлолт	1,050.4	6,978.2	1,156.9	7,602.7	6,176.1	624.5	8.9%
Бусад ашигт малтмал олборлолт	13.6	79.4	32.5	214.5	187.4	135.1	2.7 <sup>1</sup>
Уул уурхайн туслах үйл ажиллагаа	4.9	25.4	27.2	79.4	-	54.0	3.1 <sup>1</sup>
<b>БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР</b>	<b>534.1</b>	<b>3,283.7</b>	<b>661.7</b>	<b>4,490.8</b>	<b>668.4</b>	<b>1,207.1</b>	<b>36.8%</b>
<b>Үүнээс, хүнд үйлдвэр</b>	<b>120.2</b>	<b>689.9</b>	<b>123.0</b>	<b>932.2</b>	<b>98.0</b>	<b>242.4</b>	<b>35.1%</b>
Кокс болон газрын түүхий тосны боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	0.1	42.6	1.7	46.9	6.1	4.4	10.3%
Химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	0.4	5.6	0.5	3.5		(2.1)	-37.1%
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	0.2	5.9	0.5	4.4		(1.5)	-25.9%
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	76.3	337.4	91.3	444.5		107.2	31.8%
Металл боловсруулах үйлдвэрлэл	13.4	179.3	25.9	284.4	81.3	105.1	58.6%
Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1.9	7.0	1.7	15.7	10.5	8.7	2.3 <sup>1</sup>
Тээврийн хэрэгслийн бусад тоног төхөөрөмж үйлдвэрлэл	0.8	2.8	0.4	4.1		1.3	45.5%
Бусад боловсруулах үйлдвэрлэл	27.1	109.3	0.9	128.7		19.4	17.7%

Эх сурвалж: ҮСХ

Тайлбар: 1 – дахин их

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2022 оны эхний 7 сарын байдлаар 25.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 10.8 (75.5%) их наяд төгрөгөөр өссөн байна. Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 19.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 9.3 (92.5%) их наяд төгрөгөөр өсөхөд нүүрс олборлолтын салбарын борлуулалт 8.0 (3.8 дахин) их наяд төгрөг, металлын хүдэр олборлолтын салбарын борлуулалт 624.5 (8.9%) тэрбум төгрөг, газрын тосны олборлолтын салбарын борлуулалт 555.5 (4.4 дахин) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлөв.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан нийт бүтээгдэхүүнээс 17.7 их наяд төгрөг буюу 70.7 хувийг гадаад зах зээлд борлуулсан байна. Гадаад зах зээлд борлуулсан нийт бүтээгдэхүүний 17.1 их наяд төгрөг буюу 96.2 хувийг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн эзэлж байна.

### 3. ГАДААД ХУДАЛДАА

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2023 оны эхний 7 сарын байдлаар 13,722.3 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 2,494.5 сая ам.доллар буюу 22.2 хувиар өссөн байна. Экспорт импортоос давамгайлж 3,674.7 сая ам.доллараар өссөн үзүүлэлттэй гарсан байна.

#### 3.1. ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ

Нийт экспорт 2023 оны эхний 7 сарын байдлаар 8,698.5 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 2,233.5 сая ам.доллар буюу 34.5 хувиар өссөн байна.

Үүнээс: Эрдэс бүтээгдэхүүний экспорт 8,007.4 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 1,931.7 сая ам.доллар буюу 31.8 хувиар өссөн байна.

Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, цайрын баяжмал, хайлуур жонш, молибдены баяжмал, боловсруулаагүй нефть, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт, мөнгө, катодын зэс зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн нь нийт экспортын 92.1 хувийг эзэлж байна.

#### ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫН ДУНДАЖҮНЭ

Барааны нэр	Хэмжих нэгж	2022	2023	Өөрчлөлт	
		I-VII		+/-	Хувь
Чулуун нүүрс	тн/ам.дол	280.1	145.9	-134.2	-47.9%
Зэсийн баяжмал	тн/ам.дол	2,096.4	1,736.6	-359.7	-17.2%
Төмрийн хүдэр, баяжмал	тн/ам.дол	97.5	81.4	-16.1	-16.5%
Цайрын баяжмал	тн/ам.дол	2,103.2	1,606.8	-496.4	-23.6%
Хайлуур жоншны хүдэр, баяжмал	тн/ам.дол	285.6	250.2	-35.4	-12.4%
Молибдены баяжмал	тн/ам.дол	14,119.5	21,060.5	6,941.0	49.2%
Алт	тн/ам.дол	59,948.5	62,653.0	2,704.4	4.5%

Эх сурвалж: ГЕГ

Тайлбар: 1 – дахин их

#### 3.1.1. УУЛУУРХАЙ, ОЛБОРЛОХ САЛБАР

**Нүүрсний экспорт:** 2023 оны эхний 7 сарын байдлаар 5,037.8 сая ам.долларын 35,419.9 мян.тн нүүрс экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 1,942.3 сая ам.доллар буюу 62.7 хувиар, биет хэмжээгээр 24,367.9 мян.тн буюу 3.2 дахин тус тус өссөн байна. Чулуун нүүрсний 99.1 хувийг БНХАУ, 0.5 хувийг Сингапур, 0.3 хувийг БНСУ руу тус тус экспортолсон байна.

**Зэсийн баяжмалын экспорт.** 2023 оны эхний 7 сарын байдлаар 1,547.9 сая ам.долларын 891.3 мян.тн зэсийн баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 247.0 сая ам.доллар буюу 13.8 хувиар буурсан ч, биет хэмжээгээр 35.1 мян.тн буюу 4.1 хувиар өссөн байна. Зэсийн баяжмалыг 99.9 хувийг БНХАУ, 0.1 хувийг Сингапур улс руу тус тус экспортолсон байна.

**Төмрийн хүдэр, баяжмалын экспорт.** 2023 оны эхний 7 сарын байдлаар 255.7 сая ам.долларын 3,140.5 мян.тн төмрийн хүдэр, баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 32.8 сая ам.доллар буюу 14.7 хувиар, биет хэмжээгээр 853.8 мян.тн буюу 37.3 хувиар тус тус өссөн байна. Төмрийн хүдэр, баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

**Хайлуур жоншны хүдэр, баяжмалын экспорт.** 2023 оны эхний 7 сарын байдлаар 131.1 сая ам.долларын 524.1 мян.тн хайлуур жоншны хүдэр, баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 333.2 мян.тн буюу 2.7 дахин, үнийн дүнгээр 76.6 сая ам.доллар буюу 2.4 дахин тус тус өссөн байна. Хайлуур жоншны хүдэр, баяжмалын 80.2 хувийг БНХАУ, 19.7 хувийг ОХУ руу тус тус экспортолсон байна.

**Цайрын баяжмалын экспорт.** 2023 оны эхний 7 сарын байдлаар 172.6 сая ам.долларын 107.4 мян.тн цайрын баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 23.7 мян.тн буюу 28.3 хувиар өссөн, үнийн дүнгээр 3.5 сая ам.доллар буюу 2.0 хувиар буурсан байна. Цайрын баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

**Молибдены баяжмалын экспорт.** 2023 оны эхний 7 сарын байдлаар 75.5 сая ам.долларын 3,584.7 тн молибдены баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 29.0 сая ам.доллар буюу 62.2 хувиар, биет хэмжээгээр 288.4 тн буюу 8.7 хувиар тус тус өссөн байна. Молибдены баяжмалын 74.9 хувийг БНХАУ, 18.5 хувийг БНСУ руу тус тус экспортолсон байна.

**Алтны экспорт.** 2023 оны эхний 7 сарын байдлаар 396.7 сая ам.долларын 6,331.2 кг алт экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 117.4 сая ам.доллар буюу 22.8 хувиар, биет хэмжээгээр 2,244.3 кг буюу 26.2 хувиар тус тус буурсан байна. Алтны 80.7 хувийг Швейцар, 19.3 хувийг БНСУ руу тус тус экспортолсон байна.

### 3.1.2. ГАЗРЫН ТОСНЫ САЛБАР

**Газрын тосны экспорт.** 2023 оны эхний 7 сарын байдлаар 205.9 сая ам.долларын 2,776.1 мян.бар газрын тос экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 2,302.8 мян.бар буюу 5.9 дахин, үнийн дүнгээр 153.8 сая ам.доллар буюу 4.0 дахин тус тус өссөн байна. Газрын тосыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

### 3.1.3. ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

**Коксын экспорт.** 2023 оны эхний 7 сарын байдлаар 8.0 сая ам.долларын 43.6 мян.тн кокс экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 7.0 сая ам.доллар буюу 7.9 дахин, биет хэмжээгээр 41.2 мян.тн буюу 18.7 дахин тус тус өссөн байна.

**Катодын зэс:** 2023 оны эхний 7 сарын байдлаар 57.4 сая ам.долларын 6,803.3 тн катодын зэс экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 3,360.5 тн буюу 97.6 хувиар, үнийн дүнгээр 24.5 сая ам.доллар буюу 74.7 хувиар тус тус өссөн байна. Катодын зэсийн 69.1 хувийг БНХАУ, 29.7 хувийг Тайвань руу тус тус экспортолсон байна.

### 3.2. ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ

Нийт импорт 2023 оны эхний 7 сарын байдлаар 5,023.8 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 261.1 сая ам.доллар буюу 5.5 хувиар өссөн байна.

Үүнээс, Эрдэс бүтээгдэхүүний импорт 1,211.2 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 155.5 сая ам.доллар буюу 14.7 хувиар өссөн байна.

#### ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТЫН ДУНДАЖ ҮНЭ

Барааны нэр	Хэмжих нэгж	2022	2023	Өөрчлөлт	
		I-VI		Өсөлт/бууралт	Хувь
Автобензин	тн/ам.дол	835.4	716.8	-118.5	-14.2%
Дизель түлш	тн/ам.дол	930.5	790.1	-140.4	-15.1%

Эх сурвалж: ГЕГ

Тайлбар: 1 - дахин их

#### 3.2.1. ГАЗРЫН ТОСНЫ САЛБАР

Эрдэс бүтээгдэхүүний импортын үнийн дүнгийн 87.4 хувийг газрын тосны бүтээгдэхүүн эзэлж байна.

2023 оны эхний 7 сарын байдлаар 1,059.1 сая ам.долларын 1,345.0 мян.тн газрын тосны бүтээгдэхүүн импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 327.7 мян.тн буюу 32.2 хувиар, үнийн дүнгээр 132.4 сая ам.доллар буюу 14.3 хувиар тус тус өссөн байна.

Газрын тосны бүтээгдэхүүний импортын нийт үнийн дүнгийн 87.7 хувийг автобензин, дизель түлшний импорт, үүний 29.0 хувийг автобензин, 58.7 хувийг дизель түлшний импорт тус тус эзэлж байна.

**Автобензины импорт.** 2023 оны эхний 7 сарын байдлаар 307.2 сая ам.долларын 428.5 мян.тн автобензин импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 40.6 мян.тн буюу 10.5 хувиар өссөн ч, үнийн дүнгээр 16.9 сая ам.доллар буюу 5.2 хувиар буурсан байна.



---

**Дизель түлшний импорт:** 2023 оны эхний 7 сарын байдлаар 621.9 сая ам.долларын 787.1 мян.тн дизелийн түлш импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 131.3 сая ам.доллар буюу 26.8 хувиар, биет хэмжээгээр 259.9 мян.тн буюу 49.3 хувиар тус тус өссөн байна.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ